

(А-ДБ-16) Төгсөгч, мэргэжлийн чиглэлээр

ДЭД БҮЛЭГ-4.15: Төгсөлт

Тайлангийн нэр 1: ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧДИЙН 20... /20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, мэргэжлийн чиглэлээр

Товч нэр: (А-ДБ-16) Төгсөгч, мэргэжлийн чиглэлээр

Маягтын төрөл: Албан ёсны маягт

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/31 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдээллийг мэргэжлийн чиглэл бүрээр нийт төгсөгч, боловсролын зэрэг, хүйсээр ялган харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 8 сарын 1, 3 сарын 15-ны дотор

Хамрах хүрээ: Дээд боловсролын сургалтын байгууллага(ДБСБ) нь суралцагчийн төгсөлтийн мэдээллийг ДБУМС-ын “Төгсөлт” модульд бүртгэж тайлан бодуулж баталгаажуулсны дараа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БАЭТЗТБ) тайлан баталгаажуулан Үндэсний статистикийн хороонд ирүүлнэ.

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	З-ДБ-34	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр

Заавар: (А-ДБ-16) МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

А.Үндсэн мэдээлэл Нийт төгсөгчид (багана 1:3) -Тухайн хичээлийн жилд дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчдийн нийт тоог (багана 1)-т, эрэгтэй төгсөгчдийн тоог (багана 2)-т, эмэгтэй төгсөгчдийн тоог (багана 3)-т тус тус бичнэ багана1=(2+3). Дипломын боловсрол (багана 4:6) -Дипломын боловсролыг эзэмшин төгсөгчдийн нийт тоог (багана 4)-т, эрэгтэй төгсөгчдийн тоог (багана 5)-д, эмэгтэй төгсөгчдийн тоог (багана 6)-д тус тус бичнэ багана4=(5+6). Бакалаврын боловсрол (багана 7:9) -Бакалаврын боловсролыг эзэмшин төгсөгчдийн нийт тоог (багана 7)-д, эрэгтэй төгсөгчдийн тоог (багана 8)-д, эмэгтэй төгсөгчдийн тоог (багана 9)-д тус тус бичнэ багана7=(8+9). Магистрын боловсрол (багана 10:12) -Магистрын боловсролыг эзэмшин төгсөгчдийн нийт тоог (багана 10)-т, эрэгтэй төгсөгчдийн тоог (багана 11)-т, эмэгтэй төгсөгчдийн тоог (багана 12)-т тус тус бичнэ багана10=(11+12). Докторын боловсрол (багана 13:15) -Докторын боловсролыг эзэмшин төгсөгчдийн нийт тоог (багана 13)-т, эрэгтэй төгсөгчдийн тоог (багана 14)-т, эмэгтэй төгсөгчдийн тоог (багана 15)-д тус тус бичнэ багана13=(14+15). Бүгд (мөр1:26) -Нийт төгсөгчдийн тоог суралцаж төгссөн мэргэжлийн ерөнхий болон төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэлээр ангилан бичнэ. Мэргэжлийн чиглэлийн ангиллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78, 2014 оны А/370, 2015 оны А/138, 2015 оны А/262, 2017 оны А/52, 2019 оны А/336 дугаар тушаалын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын

сургалтын байгууллагад мөрдөх диплом, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”, ЮНЕСКО-гоос 2013 онд гаргасан “Боловсролын мэргэжлийн чиглэл-ISCED-F”-ийг баримтална. Боловсролын мэргэжлийн чиглэл нь 3 үе шаттай, дээрээс доош буюу ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл гэсэн тогтолцоотой, 4 оронтой тоогоор кодлогдсон байна. 10 ерөнхий чиглэл, 29 төрөлжсөн мэргэжил, 80 орчим нарийвчилсан мэргэжлээр хуваагдсан байна.

Түвшин Чиглэлийн ангилал Чиглэлийн тоо 1-р түвшин Ерөнхий чиглэл 10 2-р түвшин Төрөлжсөн мэргэжил 29 3-р түвшин Нарийвчилсан мэргэжил \cong 80

Тайлангийн нэр 2: ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧДИЙН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, өмчийн хэлбэрээр

Товч нэр: (А-ДБ-17) Төгсөгч, өмчийн хэлбэр, ангиллаар

Маягтын төрөл: Албан ёсны маягт

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/31 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн мэдээллийг сургуулийн ангилал, өмчийн хэлбэр бүрээр нийт төгсөгч, боловсролын зэрэг, хүйсээр ялган харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 8 сарын 1, 3 сарын 15-ны дотор

Хамрах хүрээ: Дээд боловсролын сургалтын байгууллага(ДБСБ) нь суралцагчийн төгсөлтийн мэдээллийг ДБУМС-ын “Төг